

АЙСЭК-ийн танилцуулга

АЙСЭК анх 1948 онд Бельги улсад байгуулагдсан ба “Энх тайван болон хүмүүний ур чадварын биелэлт” гэсэн эрхэм зорилгын дор Европын зургаан залуу анх нэгдэж, 66 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулснаар өдгөө дэлхийн 125 улсад салбартай үйл ажиллагаагаа явуулж байна.

Монголд 2008 онд Yale их сургуулийн таван залуучууд АЙСЭК-ийг байгуулсан ба Монгол дахь АЙСЭК одоогоор 50 гаруй олон улсын компанийн дадлага, 200 гаруй оюутныг гадаадад сайн дурын солилцооны хөтөлбөрт хамруулаад байна. Залуу удирдагч соёл солилцооны нийгэмлэг цаашид AIESEC Mongolia эсвэл Монгол дахь АЙСЭК өдгөө МУИС, СЭЗДС, АШУУИС, ШУТИС гэсэн томоохон сургуулиудад албан ёсны салбартай мөн жил бүр МУИС, СЭЗДС, ШУТИС, ХААИС, АШУУС зэрэг Монголын томоохон их дээд сургуулиудын 2000 гаруй оюутнуудад хүрч ажилладаг юм.

АЙСЭК-ийг тоогоор илэрхийлвэл

125 орон болон нутаг дэвсгэр
 67 жилийн туршлага
 37000 сайн дурын хөтөлбөрүүд /жилд/
 5000 компанийн дадлага /жилд/
 500 олон улсын чуулга хурлууд /жилд/
 2500 гаруй их дээд сургуулиудад салбартай
 100000+ гишүүд мөн
 1000000+ төгсөгч нарыг амжилттай бэлтгэж гаргасан юм.

Эрхэм зорилго

“Энх тайван болон хүмүүний ур чадварын биелэлт”



АЙСЭК-ийн гол үнэт зүйлс

АЙСЭК-ийн зургаан гол үнэт зүйлсийг гишүүд эрхэмлэснээр бид залуучуудыг оролцоон дээр залуу хүний манлайлах нөөц бололцоог хурцалж, манлайлагч хүнд байх зан хандлагыг хэлбэржүүлнэ. АЙСЭК-ийн зургаан үнэт зүйлсээр амьдрах нь залуучуудад нийгэмдээ эерэг үр нөлөөг бүтээх хариуцлагатай шийдэр гаргалтуудыг дэмждэг.



1. Бид хийж байгаа бүх зүйлсээ өндөр чанартай хүргэхийг зорьдог. Бүтээлч байдал болон шинэлэг санаагаар үүнийгээ бид хөгжүүлдэг.



2. Бид гаргаж байгаа үйлдэл болон шийдвэр гаргалтууд дээрээ нээлттэй мөн тууштай байдаг. Өөрсдийнхөө эрхэм зорилгод нийцэх үүднээс бид өөрсдийнхөө оролцоог чиглүүлдэг.



3. Бид манлайллыг үйлдлээрээ, хийсэн ажлаараа, мөн бусдыг хөгжүүлэхийн төлөөх хариуцлагатай байдгаараа үлгэрлэн дэмждэг.



4. Бид нийгэмдээ мөн байгууллагадаа тогтвортой байдаг. Бидний гаргаж буй шийдвэрүүд бидний залгамж халаа, шинэ үеийнхэнд хэрэгцээтэй байдаг.



5. Бид нээлттэй уур амьсгалыг бүрдүүлснээрээ гишүүддээ идэвхитэй мөн урам зоригтой байх орчныг бүрдүүлж байгаа юм.



6. Бид өөр арга барил, олон төрлийн орчинг төлөөлсөн хүмүүсээс сурахыг зорьдог. Бид бүх хүний оролцоог хүндэлдэг.

АЙСЭК-ийн ШУТИС-д явуулж буй хөтөлбөрүүд, арга хэмжээ



Оюутан солилцооны хөтөлбөр буюу Global Citizen хөтөлбөрөөр оюутан 6-8 долоо хоногын турш гадаадад сайн дураараа төсөл хөтөлбөрт ажиллаж, хөтөлбөр тус бүрийнхээ онцлогоос хамааран англи хэлний чадвар, манлайлах чадвар, илтгэх чадвар тэргүүтэй олон хувь хүний чадваруудыг эзэмших юм.

1. Цахим болон хэвлэмэл анкет бөглөх. <http://bit.ly/AIESECMUST>
2. Монгол дахь АЙСЭК-ийн гишүүдтэй анхан шатны ярилцлага өгөх.
3. Монгол дахь АЙСЭК /Залуу удирдагч соёл солилцооны нийгэмлэгтэй/ солилцоогоор явах хөтөлбөрийн гэрээ байгуулах.
4. Тухайн орны АЙСЭК-ийн гишүүдтэй хоёр дахь шатны ярилцлага өгөх.
5. Тухайн орны Виза авах өргөдөл гаргах, аяллын даатгал хийлгэх, онгоцны тасалбараа захиалах.
6. Оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдаж буй оюутнуудад зориулсан семинарт хамрагдана.
7. Оюутан солилцооны хөтөлбөртөө хамрагдаад тухайн улс уруу явна.



АЙСЭК-ийн гишүүний хөтөлбөр буюу Global Leader хөтөлбөрөөр оюутан АЙСЭК олон улсын байгууллагын гишүүн болон орж, АЙСЭК-ийн шийдвэр гаргалтууд, үйл ажиллагаа, менежмент мөн санхүүгийн шийдвэр гаргалтуудыг гаргах юм. Энэхүү хөтөлбөрөөр оюутан танхимаас олж чадахгүй практикийн чадварууд, мөн дэлхийн хамгийн том залуучуудаар удирдуулсан байгууллагийг удирдах боломжийг олж авдаг.

1. Цахим болон хэвлэмэл анкет бөглөх. <http://bit.ly/AIESECMUST>
2. Хүний нөөцийн хэлтэсээс зохиох шинэ гишүүдийн элсэлтийн мөчлөгийг хүлээх / Намар 10 дугаар сард, Хавар 2,3,4 дүгээр сард/
3. Гишүүний шинэ элсэлтийн шалгуур арга хэмжээнд өрсөлдөх.



Компанийн дадлагын хөтөлбөр буюу Global Talent хөтөлбөрөөр Монголын аж ахуйн нэгж байгууллагууд дэлхийн 125 орны залуу боловсон хүчнийг компанидаа дадлага болгон авах боломжтой.

1. Компани АЙСЭК-ийн Компанийн дадлага хариуцсан менежертэй уулзана
2. Компани шаардлагатай хүнийхээ ажлын тодорхойлолтыг өгнө.
3. Компани Монгол дахь АЙСЭК-тэй гэрээ байгуулна.
4. Дадлагажигч сонгон шалгаруулалт.
5. Дадлагажигч ирэхээс өмнөх бэлтгэл ажил.
6. Дадлагажигч компанидаа дадлага хийнэ.

English Speaking Corner

English Speaking Corner оюутан залууст зориулсан англи хэлний ярианы клуб юм. Энэхүү үйл ажиллагаа нь сонирхолтой аргаар англи хэлний ярианы чадвар хөгжүүлэх цогц дасгалуудаас бүрднэ.

1. Movie Corner

Энэ дасгалаар англи хэл дээр орчуулгагүй киног үзэж, киноныхоо төгсгөлд хэлэлцүүлэг явуулдан сонирхолтой аргаар англи хэлээ хөгжүүлнэ.

2. Global Village

Энэ дасгалаар орон орны өртөөгөөр чимэн тохижуулсан танхимд оюутан залуус улс орны соёлтой танилцаж, тухайн орны соёлын эд зүйлс, нийгмийн шинж чанарын харуулсан ном, хэвлэмэл материал, үндэсний хувцас нарыг англи хэл дээр мэдэж авна.

3. Debate Corner

Энэ дасгалаар англи хэл дээр сэдвийн дор мэтгэлзэж, тухайн сэдвийн хүрээнд буй шинэ үгс, нэр томъёог сурч авах юм.

4. Fun corner

Энэ дасгалаар сонирхолтой тоглоомуудыг ээлжлэн англи хэл дээр тоглоно.

Winter National leadership development seminar

Энэхүү хурлаар олон улсын шилдэг их дээд сургуулиудын оюутнууд, мөн Монгол дахь АЙСЭК-ийн гишүүд Монгол дахь АЙСЭК-ийн ирээдүйн стратеги, шийдвэр гаргалтуудыг гаргадаг.

WNLDS 2014

2014 оны 1 сарын 13-18-нд Эрдэнэт хот “Gold Hotel”

Ерөнхий ивээн тэтгэгч: Голомт Банк,

Хамтран ажиллагч: “МСиЭс” Кока Кола



+

WNLDS 2015

2015 оны 1 сарын 13-19-нд Дархан хот “Дархан зочид буудал”

Хамтран ажиллагч: Голомт Банк, “МСиЭс” Кока Кола, Витафит компани



Contact Details

Oyundari Otgonkhoo /Director of Global Citizen programme /

+976 94060291

oyundari.otgonkhoo@aiesec.net

Tselmeg Davaajav /President of AIESEC MUST /

+976 95194321

tselmeg.davaajav@aiesec.net

